

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫГ
ДЭМЖИХ "ГЭГЭЭ МАНДАЛ" САН**

**“НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГО”
ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛАГА**

**Улаанбаатар хот
2007 он**

ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО

Нийгмийн халамжийн салбарт өнөөгийн үйлчилж байгаа нийгмийн халамжийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалалын тухай хуулиуд түүнээс урган гарсан тогтоол, тушаал, заавар, аргачлалын зарим заалтууд нь амьдралд тэр бүр нийцэхгүй байгааг олон нийт, иргэд шүүмжилдэг. Эдгээр хуулиудад Нээлттэй нийгэм форумын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд "Нийгмийн халамжийн бодлого" төслөөр мониторинг явуулахдаа баримт, судалгаанд түшиглэн үнэлгээ, дүгнэлт боловсруулж амьдралд нийцэхгүй байгаа халамжийн хууль тогтоомж, тушаал, аргачлалын заалтуудыг тодруулах, бодлого хэрэгжүүлэх шатанд тохиолдож байгаа саад бэрхшээлийг хэрхэн арилгах ямар арга хэмжээ авах шаардлагатай тодруулж холбогдох газар нь өргөн мэдүүлэх явдал төслийн гол зорилго болно.

Нэг. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУГАЦАА

Төслийн хамрах хүрээ нь Монгол Улсын хэмжээнд явуулах ба Говьсүмбэр аймгийн төвийн баг, Баян тал, Шивээ говь сум, Орхон аймгийн Баян өндөр,Жаргалант сум, Булган аймгийн Хялганат сум Өвөрхангай аймгийн Арвайхээр,Уянга,Сант сум, Улаанбаатар хотын Баян гол, Чингэлтэй дүүргүүдэд тус бүр 3 хороонд мониторингийн судалгааны гол бааз болгон сонгож ажиллана.

Мониторинг хийж дуусах нийт хугацаа 24 долоо хоног байна. Бид үйл ажиллагаагаа 2007 оны 1-р сарын 15-ээс эхлэн 2007 оны 7 сарын 15-н гэхэд бүрэн дуусгасан байна.

Төслийг хийх бэлтгэл үе шатанд судалгаа явуулах талаар мэргэжлийн хүмүүсээс зөвлөлгөө авч арга зүйгээ тодорхойлох, материал, баримт бичгүүдийг цуглуулах ажлыг холбогдох газруудаас авч нэгтгэн ашиглана. "Нийгмийн халамжийн тухай" хууль түүнтэй холбоотой бусад хуулиуд болон дагалдан гарсан эрхийн актууд, тайлан, статистик мэдээ баримтыг цуглуулж түүвэрлэнэ. Халамж үйлчилгээ хүртэгч болон нийгмийн ажилтан,судлаач нартай явуулах ярилцлага анкет,асуулгын судалгааны хуудас боловсруулж бэлэн болгоно.

Төслийн анхан шатны нэгжээс өгөгдөл цуглуулах үе шатанд урьдчилан боловсруулсан арга зүй, асуулгын дагуу судлаачид ба халамжийн үйлчилгээ хүртэгч нараас халамж үйлчилгээний хэрэгжилт, үйлчилгээ үзүүлж буй аргачлал түүний бүтэц зохион байгуулалтын байдлыг сонгогдсон хороо, сумдад ярилцлагын, асуулгын, кейсийн аргаар судалгааг явуулна.Мөн баримт бичгийн судалгааг хийж аргачлалын талаарх мэдээллийг цуглуулна.

Төслийн судалгааны өгөгдөлд боловсруулалт хийх үе шатанд халамжийн үйлчилгээний талаар судлаачид мөн үйл ажиллагаа явуулдаг албан байгууллагуудаас гаргасан баримт бичиг, статистик мэдээ, судалгааны материалыг нэгтгэж дүгнэлт гаргана. Мөн анхан шатны нэгжээс цуглуулсан судалгааны өгөгдөлд үр дүнгийн боловсруулалт гажуудалд дүн шинжилгээ хийнэ.

Хоёр.ТӨСЛИЙН ҮР ДҮН

- Нийгмийн халамжийн салбарт баримтлаж байгаа өнөөгийн бодлого нь тус салбарт баримтлаж байгаа бусад салбар чиглэлийн

бодлоготой хэрхэн уялдаж байгааг үзүүлэх ба нэн ялангуяа нийгмийн эмзэг бүлэгт багтаж байгаа иргэдийг /хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ ажлын байраар хангах, хөдөлмөр эрхлэх чиглэлээр ямар бодлого баримтлаж бодитой арга хэмжээ авч байгаа болон энэ чиглэлд “Нийгмийн халамжийн тухай” хууль яаж зохицож байгааг үзүүлнэ.

- Халамжийн салбарт зарцуулж байгаа нийт хөрөнгийн хичнээн хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шууд хүрч байгааг тоон үзүүлэлтээр гаргаж мониторинг явуулсан аймаг орон нутагт тэдний амьдрал ямар түвшинд байгааг тодруулж олон нийтэд танилцуулна.
- Хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс доош хувиар алдсан ,бие дааж амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн халамжийн тэтгэврээс хасагдсан бөгөөд тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар хороо баг, халамж, хөдөлмөр эрхлэлт хариуцсан байгууллагууд хэрхэн дэмжиж туслаж байгааг баримтаар гарган үзүүлнэ.
- Нийгмийн бодлогын зарим алдаанаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний хамрах хүрээ хумигдаж нэн ядуучуудын эгнээ тэлж байгааг мониторинг хийсэн орон нутгаас баримтаар гаргаж хэвлэл мэдээлэлийн хэрэгслэлээр олон нийт,төр засаг,холбогдох газрын сонорт хүргэж нөлөөлөл үзүүлнэ. Бодлогын алдаа ямар асуудлууд дээр гарч байгааг тооцон хэрхэн арилгах арга замыг тодорхойлж зөвлөнө.
- Мониторингийн эцсийн үр дүнг радио, телевиз, сонин, интернэтээр дамжуудан олон нийтэд хүргэнэ.

Төслийн тайланг боловсруулж, эцэслэх үе шатанд өмнө хийгдсэн үйл ажиллагаануудын үр дүнг нэгтгэн судалгааны эцсийн тайланг боловсруулж Нээлттэй нийгэм форумд хүлээлгэн өгнө

Төслийн удирдлага

Төслийн удирдагч С.ГАНСҮХ
Төслийн нарийн бичгийн дарга,
"ГЭГЭЭМАНДАЛ" сангийн захирал Д.ОД

Төсөл хэрэгжүүлэх нэгж

СБД Бага тойрог Эрхүүгийн гудамж
Сэргээн засалтын үндэсний
төвийн байр

Утас: 11 450150, 9916 7385

[E-mail:mongolia_gm_org@yahoo.com](mailto:mongolia_gm_org@yahoo.com)